# "ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ" ХХК-ИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН

**2025.07.08**

| д/д | Арга хэмжээ, зорилт | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 1. Төмөр замын тээврийн хэмжээг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| 1.1 | Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Цогтцэций чиглэлийн төмөр замын тээвэрлэлтийг нэмэгдүүлэх | | Ачааны хэмжээ, сая.тонн | 2024 онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 1.752 сая.тонн, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 2.405 сая.тонн, нийт 4.157 сая.тонн ачааг тээвэрлэсэн. | **I улирал:** Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 0.56 сая.тн, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 0.84 сая.тн нийт 1.4 сая.тег<br>**II улирал:** Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 1.0 сая.тн, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 0.75 сая.тн нийт 1.75 сая.тн<br>**III улирал:** Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 0.89 сая.тн, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 0.7 сая.тн нийт 1.6 сая.тн<br>**IV улирал:** Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 0.89 сая.тн, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 0.76 сая.тн нийт 1.7 сая.тн | Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 0.19 сая.тн ачаа тээвэрлэж 34 хувийн биелэлттэй, Тавантолгой-Цогтцэций чиглэлд 0.22 сая.тн ачаа тээвэрлэж 26 хувийн биелэлттэй, нийт 0.41 сая.тн ачааг тээвэрлэж төлөвлөгөө 29.2 хувийн биелэлттэй байна.<br>***Тайлбар;***<br>*/Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр* | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | *зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн.* | |
| 1.2 | Тээвэр зуучлалаар 60,000 тн ачаа тээвэрлэх. | | Ачааны хэмжээ, тонн | Тээвэр зуучлалаар 2024 онд өдрийн байдлаар 101,392 тн ачаа тээвэрлэсэн. | Тээвэр зуучлалаар:<br>**I улиралд:** 10.000 тн.<br>**II улиралд:** 10.000 тн.<br>**III улиралд:** 20.000 тн.<br>**IV улиралд:** 20.000 тн. | "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн тээвэр зуучлалаар "Цемент шохой" ХХК-ийн 1705.87 тн,<br>"МАК цемент" ХХК-ийн 1699.02 тн,<br>"Ялгуун лайм" ХХК-ийн 4990.86 тн нийт 8,395.75 тн ачааг тээвэрлэж төлөвлөгөө 84%-ийн биелэлттэй байна.<br>*/Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн./* | 90% |
| 1.3 | Төмөр замын тээврийн технологийн бичиг баримтуудад өөрчлөлт оруулж батлуулж мөрдөх. | | Батлуулсан баримт бичгийн тоо | 2024 онд тээврийн үйл ажиллагаатай холбоотой 3 журам, 14 заавар, 1 дэглэм, 1 гарын авлага, 14 технологийн бичиг баримтыг батлуулан мөрдөж ажиллаж байна. | **I-IV улирал:** Тавантолгой, Гашуунсухайт өртөө, зөрлөгүүдийн ТЗА, ТТӨ, ГСӨ-дийн технологийн горим, сэлгээний зааврууд болон бусад 12 бичиг баримтад хуульд орсон өөрчлөлтийн дагуу нэмэлт, өөрчлөлтийг үе шаттай хийж батлуулсан байна. | Гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/32 тушаалаар SD70Ace/LW загварын зүтгүүр, GCY-300K моторт вагоны түлшний нормыг баталсан.<br>Мөн Гүйцэтгэх захирлын 2024 оны 12 дугаар сарын 10-ны А/209 дүгээр тушаалаар "Зүтгүүрийн аж ахуйн хэлтсийн нэгдсэн технологийн горим"-ыг шинэчлэн баталсан. 2025 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оны 03 дугаар сарын 24-ний өдрийн А/28 дугаар тушаалаар 6540 агаар хуваарилагчийн, 6532 загварын авто дэглэмийн, 6581 загварын авто тохируулагчийн, 6540.01 ажлын камерын засварын 4 зааврыг тус тус баталсан.<br>/Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн./ | |
| 1.4 | Эргэдэг автоугсраа бүхий ачааны нэг хагас вагон угсрах. | - | Гүйцэтгэлийн хувь | Гүйцэтгэх захирлын 2024 оны А/139 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдан, төлөвлөгөөний дагуу ажиллан, нэг ачааны хагас вагон угсрахад шаардлагатай сэлбэг, хэрэгслийн жагсаалтыг гаргасан. | **I-II улирал:** Эргэдэг автоугсраа бүхий ачааны нэг хагас вагон угсарч, холбогдох тусгай зөвшөөрлийг авч, төмөр замын тээвэрт оролцуулсан байна. | Компанийн Гүйцэтгэх захирлын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/43 дугаар тушаалын дагуу томилогдсон ажлыг хэсэг "Эргэдэг автоугсраа бүхий ачааны хагас вагон"-ыг Гашуунсухайт засварын төвийн 14-р зам дээр 2025 оны 04 дүгээр сарын 23-25-ны өдөр угсралтын ажлыг гүйцэтгэсэн. Шинээр угсарсан вагоныг SD70Ace/Lw-4110 загварын зүтгүүр болон 20606059 дугаартай 13-6724 загварын тавцант вагонд холбож Гашуунсухайт өртөөний зүтгүүр эргэх 17-р тойрог 3171м урттай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | замаар аялуулах үед автотоормосны ажиллагаа хэвийн, СА3-FR, СА3-F эргэдэг автоугсрааны холболт, салгалтын ажиллагаа хэвийн, тэргэнцэр, хос дугуйн ажиллагаа тус тус хэвийн байсан. | |
| 1.5 | Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний г нэмэгдүүлэх | - | Хөдлөх бүрэлдэхүүний тоо | Нийт 829 ш хөдлөх бүрэлдэхүүнтнй. Үүнээс Зүтгүүр 16ш Ачаны вагон 810ш Зорчигчийн вагон 1ш Тусгай зориулалтын 2ш | I-II улирал; Төмөр замын хөдлөх бүрэлдхүүнийг 1ш зорчигчийн вагоноор нэмэгдүүлнэ. | Зорчигчийн вагон худалдан авах - "ТТЗ" ХХК-ийн ТУЗ-ийн 2025.02.21-ний А/07 шийдвэрийн дагуу худалдан авах ажиллагааг зогсоосон тул ТУЗ-ийн шийдвэрийг хүлээж байна. | 0% |
| 1.6 | Зүтгүүрийн ашиглалт болон засварын зааврыг орчуулж батлуулах. | - | Зааврын тоо | SD70ACe/LW серийн зүтгүүрт хийгдэх төлөвлөгөөт засвар үйлчилгээний 5 технологийн горим боловсруулсан, төлөвлөгөөт бус засвар үйлчилгээний 20 технологийн горимыг ЗААХ-ын ИТА нар орчуулж боловсруулан батлуулсан. | **I-II улирал:** SD70Ace/LW серийн зүтгүүрийн ашиглалтын зааврыг орчуулсан байна.<br>**III улирал:** SD70Ace/LW серийн зүтгүүрийн засварын зааврыг орчуулсан байна.<br>**IV улирал:** SD70Ace/LW серийн зүтгүүрийн засварын зааврыг батлуулсан байна. | SD70ACe/LW зүтгүүрийн машинчийн ашиглалтын заавар 210 хуудас, SD70ACe/LW зүтгүүрийн үйлчилгээний заавар 574 хуудас материалыг орчуулж, эхийг бэлтгэн бэлэн болгосон. | 100% |
| 1.7 | Хөдлөх бүрэлдэхүүний г өвлийн тээвэрт бэлтгэх. | - | Тээвэрт бэлтгэсэн тоо | 2024 онд хөдлөх бүрэлдэхүүнийг өвлийн тээвэрт бэлтгэсэн. | **IV улирал:** Хөдлөх бүрэлдэхүүнийг өвлийн тээвэрт бэлтгэнэ. | Хугацаа болоогүй | - |
| 1.8 | Тавантолгой Гашуунсухайт чиглэлд Төмөр замаар зорчигч тээвэрлэх. | - | Зорчигчийн тоо | 2024 онд Тавантолгой Гашуунсухайт чиглэлд 2914 зорчигч тээвэрлэсэн. | **I-IV улирал:** Тавантолгой Гашуунсухайт чиглэлд зорчигч тээврийг аюулгүй зохион байгуулна. | Тайлант хугацаанд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 22 галт тэрэг 676 зорчигч, Гашуунсухайт-Тавантолгой чиглэлд 22 галт тэрэг 734 зорчигч тээвэрлэж, нийт дүнгээр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 44 галт тэрэг, 1410 зорчигч тээвэрлэсэн байна. */Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн./* | |
| 1.9 | Тавантолгой түлш ХХК-ийн сайжруулсан шахмал түлшний түүхий эд /мидлинг/-ийг төлөвлөсөн хэмжээнд тээвэрлэх | - | Төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувь | 2024 онд 517 мян,ган тн тээвэрлэсэн буюу 95,3 хувийн гүйцэтгэлтэй. | **I-IV улирал** Төлөвлөгөөний гүйцэтгэл 100%-д хүргэнэ | 2025 оны 1 дүгээр улиралд Тавантолгой түлш ХХК нь 2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн "Суурь бүтэц хооронд дамжин өнгөрөх ачааны хэмжээ тохиролцох ээлжит зөвлөгөөний протоколоор 147.1 мян.тн сайжруулсан шахмал түлшний түүхий эд тээвэрлэхээр төлөвлөсөн боловч Монгол улсын Засгийн газар "Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо"-ний хурлаас шахмал түлшний үндсэн түүхий эдийг өөрчлөн, 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс өөр түүхий эдээр шахмал түлш үйлдвэрлэх шийдвэр гаргасны дагуу 2025 оны 1 дүгээр улиралд 50 мян.тн мидлинг тээвэрлэхээр | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөө өөрчлөгдсөн. 50 мян.тн тээвэрлэхээс 36.02 мян.тн мидлинг тээвэрлэж тээвэрлэлтийн төлөвлөгөөг 72 хувийн гүйцэтгэлтэй ажилласан. | |
| 1.10 | ТЗХАБ-ын гишүүн орнуудын 3 дугаар хэсгийн төмөр замуудаар 2025 онд олон улсын харилцаанд ачаа тээвэрлэлтийн хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээг зөвшилцөх хуралдааныг Улаанбаатар хотноо зохион байгуулахад хамтран оролцох. | Батлагдсан төсөвт | Ажлын гүйцэтгэл, хувь | Шинээр | **I улирал:** Хуралдаан зохион байгуулах бэлтгэл хангана.<br><br>**II улирал:** Хуралдаанд оролцоно. | Зам, тээврийн сайдын 2025.02.04-ний А/25 дугаар тушаалын дагуу байгуулагдсан ажлын хэсэгт "ТТЗ" ХХК-ийн 3 ажилтан 2025.03.10-2025.03.15-ны өдрүүдэд ажлын хэсэгт орж ажилласан. | 100 |
| 1.11 | Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын төмөр замуудын төлөөлөгчдийн зөвлөгөөн болон Монгол-Орос, Монгол-Хятадын хилийн төмөр замын комиссын зөвлөгөөнийг | Батлагдсан төсөвт | Ажлын гүйцэтгэл, хувь | Шинээр | **III улирал:** Хуралдаан зохион байгуулах бэлтгэл хангах ажилд оролцоно.<br><br>**IV улирал:** Хуралдаанд оролцоно. | Хугацаа болоогүй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Улаанбаатар хотноо зохион байгуулахад хамтран оролцоно. | | | | | | |
| 1.12 | Төмөр замын зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичиг боловсруулах | | Бодлогын баримт бичиг боловсруулах ажлын гүйцэтгэл | Засгийн газрын 2021 оны 11 дүгээр тэмдэглэл гарсан. | **II улирал:** Төмөр замын Зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төсөл боловсруулна.<br><br>**III-IV улирал:** Төмөр замын Зорчигч тээврийн талаар баримтлах бодлогын баримт бичгийн төслийг батлуулна. | */Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн./* | 0 |
| **Зорилт 2. Монгол улсын хөгжлийн бодлогод туссан төмөр замын бүтээн байгуулалтын төсөл хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| 2.1 | Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын төслийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх. | - | Гүйцэтгэлийн хувь | Барилгын ажлын гүйцэтгэл-0% | **I улирал:** Санхүүжилтийн гэрээ болон барилга угсралтын гэрээг байгуулсан байна.<br>**II улирал:** Барилгын ажил эхлэхтэй холбоотойгоор холбогдох зөвшөөрөл, газар чөлөөлөлт, кемпийн бэлтгэл ажил бүрэн хангагдан барилгын ажил эхлүүлсэн байна. | **Санхүүжилтийн гэрээний талаар:**<br><br>Гүйцэтгэх захирлын 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/166 дугаар тушаалаар Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын төслийн бүтээн байгуулалтын "Санхүүжилтийн гурван талт гэрээ"-ний төслийг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Санхүүжилтийн гэрээний төслийг Гүйцэтгэх захирлын 2025 оны 04 | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | **III улирал:** Барилгын ажлын гүйцэтгэл 5 хувьд хүрсэн байна.<br>**IV улирал:** Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувьд хүрсэн байна. | дүгээр сарын 16-ны өдрийн А/37 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэгт танилцуулж, 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 01/1026 дугаар албан бичгээр "Эрдэнэс тавантолгой" ХК-д хүргүүлсэн боловч тус компанийн зүгээс тодорхой хариу ирүүлээгүй байна.<br>**Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх гэрээний талаар:**<br>Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн А-1/1752 дугаартай "Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл"-д заасны дагуу "Хятадын төмөр замын барилгын гүүрийн инженерийн групп" ХХК нь Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын гүйцэтгэгчээр шалгарсан байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 176 дугаар тогтоолоор Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын барилгын ажлын гүйцэтгэгчийн тендер шалгаруулалт болон барилгын ажил гүйцэтгэх гэрээнд Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC)-ны гэрээний жишиг нөхцөлийг тусгаж хэрэгжүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг даалгасан.<br>"Тавантолгой төмөр зам" ХХК болон БНХАУ-ын "Төмөр замын барилгын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гүүрийн инженерийн товчоо групп" ХХК нарын хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэх гэрээг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажил Монгол, Хятад хоёр улсын хилийн шугам дээр хоёр талаас дам нуруут гүүрний анхны шон суурийн өрөмдлөгийг албан ёсоор 2025 оны 06 дугаар сарын 15-ны өдөр эхлүүлэн бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.<br>**Холбогдох зөвшөөрлийн талаар:**<br>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 157 дугаар тогтоолоор Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэхтэй холбогдуулан улсын хилийн зурваст бүтээн байгуулалтын хаалттай бүс байгуулах асуудлыг шийдвэрлэхийг даалгасан.<br>Энэ хүрээнд Монгол Улсын Сайд, Боомтын сэргэлтийн үндэсний хорооны даргын 2025 оны 04 сарын 10-ны өдрийн А/30 тушаалаар Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын барилгын бүсэд техник, тоног төхөөрөмж, барилгын болон өдөр тутмын бараа материалыг улсын хилээр нэвтрүүлэх зохицуулалтыг хийх, Бүгд Найрамдах Хятад Ард | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Улсын талтай ажлын уялдаа холбоог хангаж, бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд нийт 3 удаагийн хамтарсан уулзалтыг зохион байгуулсан. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын гүүрийг хамтран барих тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах хүрээнд "Бүтээн байгуулалтын хаалттай бүс"-д мөрдөх түр журмын төслийг боловсруулан батлуулахаар ажиллаж байна. Төслийн хүрээнд Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах тухай 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01/1057 дугаартай албан бичгийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газарт, 2025 оны тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулах хүсэлтийг 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яаманд (Байгаль орчны мэдээллийн сан eic.mn) тус хүргүүлсэн. Мөн Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах зөвшөөрөл хүсэх тухай албан бичгийг Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газарт 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн 01/1033 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Дээрх хүсэлтүүдийн дагуу тухайн байгууллагуудтай уулзалт зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулсан бөгөөд төслийн Ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсны дараа зөвшөөрлийг олгохоор хүлээгдэж байна. | |
| 2.2 | Компанийн хэрэгжүүлж байгаа төслүүдийг бүрэн дуусгаж гэрээг дүгнэх. | - | Баталгаажуулсан актын тоо | Төслүүдийн ажил хүлээлцэх акт, явц дундын төлбөрийн хүсэлтүүд батлагдсан. | **I улирал** Тавантолгойн нүүрс ачих логистикийн төв төслийн гэрээг дүгнэж хаасан байна, Зүгшрүүлэлтийн тээврийг эхлүүлсэн байна.<br>**II улирал:** Тавантолгой-Гашуунсухайт төмөр замын цогцолбор төсөл, Тавантолгой-Зүүнбаян холболтын төмөр замын төсөл, Шилжүүлэн ачих Терминал төслийн гэрээг дүгнэсэн актыг дүгнэж хаасан байна. | ТНАЛТ: Төслийн гэрээ хаах бэлтгэл ажлыг ханган төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.<br>Санхүүжилтийн гэрээ болон EPC гэрээ дүгнэх актын төсөл боловсруулагдсан.<br>Багц 1, 5, 6 болон Багц 1–4, 6-д хамаарах Эд хөрөнгийг Талуудын хамтарсан Ажлын хэсгийн гишүүд төслийн талбайд тоолж бүртгэлжүүлж, акт үйлдэн баталгаажуулсан бөгөөд Эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулахаар "Эрдэнэс Тавантолгой" ХК-д хүргүүлсэн, хариу хүлээгдэж байна.<br>2025 оны 02 дугаар сарын 24-ний "ЭТТ" ХК, "ТТЗ" ХХК болон "БИ" ХХК нарын холбогдох албан тушаалтнуудын уулзалтаар Зүгшрүүлэлтийн хугацааг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс тооцохоор хэлэлцсэн. Зүгшрүүлэлтийн хугацаа эхэлснээр ТНАЛТ-ийг Ашиглагч тал хариуцах юм.<br>2025 оны 06 дугаар сарын 04-ний өдөр "ЭТТ" ХК-ийн удирдлагууд "ТТЗ" ХХК-ийн Гүйцэтгэх захирал болон ТНАЛТ төсөлтэй холбоотой холбогдох ажилтнуудтай уулзалт хийж Ашиглагч, Захиалагч, Ерөнхий гүйцэтгэгч нарын шийдвэр гаргах түвшний удирдлагууд болон мэргэжлийн инженерээр бүрдсэн төлөөлөл төслийн талбайд ажиллаж | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төслийн гэрээг хаах, акт баталгаажуулах, шаардлагатай асуудлуудыг шийдвэрлэхээр тохиролцсон. Энэ хүрээнд төслийн талбайд ажиллах тухай 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1259, 01/1260 дугаар албан бичгийг "ЭТТ" ХК болон "БИ" ХХК нарт хүргүүлсэн. | |
| 2.3 | Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах. | - | ШУТЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан эсэх | "Алсын хараа-2050" бодлогын баримт бичгийн 8.2.2 -т заасан уул уурхай, экспортын чиглэлийн авто зам болон төмөр замыг хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрт "Шивээхүрэн-Тавантолгой" чиглэлд төмөр зам барих талаар тусгагдсан. 2024.10.04-ний өдрийн А/160 ажлын хэсэг байгуулагдсан, ТЭЗУС боловсруулагдаж байна. | **I улирал:** Зам, тээврийн яамны дэргэдэх ШУТЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан байна. | "Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн" чиглэлийн төмөр замын Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа хэлэлцүүлэх тухай" албан бичгийг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр 01/379 дүгээр албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. Зам, тээврийн яамнаас 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн 08/1150 тоот албан бичгээр Техник эдийн засгийн урьдчилсан судалгааг дахин сайжруулах тухай хариуг ирүүлсний дагуу сайжруулалт хийж байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 103 дугаар тогтоолтой хамааралтай компанийн өөрчлөлтөөс шалтгаалан "Тавантолгой-Даланзадгад-Шивээхүрэн" чиглэлийн ТЭЗҮ боловсруулах ажлын хэсэг байгуулах ажил тодорхойгүй хугацаагаар хойшилсон. | 30% |
| 2.4 | Хөдлөх бүрэлдэхүүн угсрах технологийн төв ТЭЗҮ боловсруулах. | 327,356,000.0 /ТЭЗҮ боловсруулахад шаардлагатай | ШУТЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан эсэх | 2024.09.05-ны өдрийн А/138 дугаартай Төмөр замын Хөдлөх бүрэлдэхүүн угсралтын технологийн төвийн ТЭЗУС боловсруулах ажлын хэсэг | **I улирал:** Хөдлөх бүрэлдэхүүн угсралтын технологийн төвийн ТЭЗУС-ийг Зам, тээврийн яамны дэргэдэх ШУТЗ-өөр хэлэлцүүлж батлуулсан байна. | 2024 оны 12 дугаар сарын 1/3249 тоот албан бичгээр ЗТЯ-ны дэргэдэх ШУТЗ-д ТЭЗУС-ийг хүргүүлсэн. 2025 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр 08/191 тоот албан бичгээр зөвлөмж ирүүлсэн тул санал зөвлөмжийн дагуу сайжруулалт боловсруулалт хийж | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | төсвийн зардал/ | | байгуулагдсан. ТЭЗУС-ын гүйцэтгэл 60%-тай. | | 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр дахин хэлэлцүүлэхээр ШУТЗ-д хүргүүлсэн. 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр ЗТЯ-ны Төмөр замын, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Х.Итгэл даргад танилцуулсан. Хариуг албан бичгээр хүргүүлэхээр болсон. | |
| 2.5 | "Богдхан төмөр зам" төслийн хүрээнд аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан барилга угсралтын ажил гүйцэтгэх гэрээг дүгнэх, холбогдох байгууллагад төслийн хүрээний баримт материалуудыг хүлээлгэн өгөх. | 2,196,984, 412.68 | Ажлын явц | Аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээг дүгнэхтэй холбоотой хэрэгжүүлж буй арга хэмжээний гүйцэтгэл 30%-тай байна. | **I-II улирал:** Холбогдох гэрээнүүдийг тус бүр дүгнэж, төрийн эрх бүхий байгууллагаас тодорхойлсон байгууллагатай баримт материалуудыг хүлээлцсэн акт үйлдэж гүйцэтгэл 100%-д хүрсэн байна. Маргаан гарсан тохиолдолд холбогдох байгууллагаар эцэслэн шийдвэрлүүлсэн байна. | Зам, тээврийн яамны 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 08/904 дугаартай "Нэрс ирүүлэх тухай" албан бичгийг ирүүлсэн. Албан бичигт Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 3 дугаар тэмдэглэлд Богдхан төмөр замын төслийн явц цаашид авах арга хэмжээний талаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд танилцуулах асуудлыг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг даалгасан тул танилцуулга, материал бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт орж ажиллах нэрс ирүүлэх тухай дурдсан. Холбогдох ажилчдын нэрсийг хүргүүлсэн ба ажлын хэсгийн тушаал батлагдаагүй байна.<br>Шилжсэн учраас МТЗ аас тээврийн үйл ажиллагааны хоногийн мэдээгээ гаргаж байгаа. | 30% |
| **Зорилт 3. Суурь бүтцийн бүрэн бүтэн байдал, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангана.** | | | | | | | |
| 3.1 | Компанийн эзэмшлийн 100 ширхэг хагас вагоныг дунд | | | Компанийн 2025 оны үйл ажиллагааны төсөвт 100 хагас вагоны дунд засварт шаардлагатай сэлбэг, | **I улирал:** 100 хагас вагоны дунд засварт шаардлагатай сэлбэг материалыг бүрдүүлсэн байна. | "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд вагоны сэлбэг, | 0% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | засвараар засварлах сэлбэг, хэрэгслийн нөөцийг бүрдүүлж, засварлах ажлыг гүйцэтгэх. | - | Гүйцэтгэлийн хувь | хэрэгсэл, материалын зардлын саналыг хүргүүлсэн. Ачааны вагоны дунд засварын технологийн горим болон засварын үнэлгээг тус тус батлуулсан. | **II улирал:** 50 хагас вагоныг дунд засвараар засварлаж Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан байна.<br>**III улирал:** 50 хагас вагоныг дунд засвараар засварлаж Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан байна. | хэрэгслийн худалдан авалт хүлээгдэж байна.<br>Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн. | |
| 3.2 | Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, засвар үйлчилгээ, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалт, ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах. | - | Ажлын явц | Төмөр замын тээврийн тухай хууль болон бусад тушаал шийдвэрийг мөрдөж ажилласан. | **I улирал:** Галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж ажиллах төлөвлөгөөг батлуулсан байна.<br>**I-IV улирал:** Төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүний ашиглалт, засвар үйлчилгээ, галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалт, ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаанд гарч буй үл тохирлыг давтан гаргуулахгүй байх дээр хяналт тавьж, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулж ажилласан байна. | Үер усны аюулаас зам байгууламжийг урьдчилан сэргийлж, бэлтгэл ажлыг хангах, арчлах зорилгоор "Үер усны идэвхжилтээс өмнө хийх хойшлуулшгүй ажлын төлөвлөгөө" болон "Элсэнд дарагдсан суваг шуудуу, гүүр хоолойн голдирол, ул шорооны дэнж цэвэрлэх ажлын төлөвлөгөө"-г Гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/25 дугаар тушаалаар баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Мөн төлөвлөгөөт хугацаанд Тавантолгой өртөөний депогийн сум №110 дугаар сумыг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зүссэн гологдол гарсныг цаг алдалгүй засварлан галт тэрэгний | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган ажилласан. Засгийн газрын 2025 оны “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг “Монголын төмөр зам” ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, “Тавантолгой төмөр зам” ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн. | |
| 3.3 | Замын байгууламжуудын найдвартай, бүрэн бүтэн байдлыг хангах. | | Ажлын гүйцэтгэлээр | Төмөр замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үүднээс давхардсан тоогоор зам хоорондын 94477 пог/м элс цэвэрлэх ажил хийсэн. | **I улирал:** Замын байгууламжийн бүрэн бүтэн байдал, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг байнгын хангах төлөвлөгөө батлуулах.<br>**I-IV улирал:** Төлөвлөгөөний дагуу ажиллаж, шаардлагатай тохиолдолд тухай бүр ажлын хэсэг зохион байгуулж ажилласан байна. | Суурь бүтцийн газрын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Давхардсан тоогоор зам хоорондын 5212 пог/м элс цэвэрлэх ажил, замын төхөөрөмж байгууламжийн арчилгааг уулзвартай зам, уулзваргүй зам, суман шилжүүлэг гэсэн 3 бүлэгт багцлан 77 нэр төрлийн ажлыг хийж гүйцэтгэсэн.<br>Засгийн газрын 2025 оны “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн. | |
| 3.4 | Гол зам, хүлээн авах, явуулах зам сум, салбар зам, гарам, хориг хашаа, гүүр хоолойнуудын урсгал засварыг хийх, нөөц бүрдүүлэх, суваг шуудууны элсийг цэвэрлэх. | | Илэрсэн дутагдлыг арилгасан эсэх | 2024 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар: Батлагдсан төлөвлөгөө, графикийн дагуу суман шилжүүлэгт 3671 ш, гүүр хоолойд 2956 ш, гарамд 121 ш үзлэг шалгалтыг хийсэн биелэлт 100 хувьтай байна. Хориг хашаанд нийт 112179.8 км-т үзлэг хийж биелэлт 100 хувийн гүйцэтгэлтэй байна. Шуудууны элс 16160м цэвэрлэж, 18890 м3 хаягдал элс зөөвөрлөсөн. | **I улирал:** Урсгал засвар хийх, нөөц бүрдүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна.<br>**I-IV улирал:** Явуулах зам сум, салбар зам, гарам, хориг хашаанд үзлэг шалгалт хийж шалгалтаар илэрсэн дутагдлыг арилгаж ажилласан байна. | Суурь бүтцийн газрын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталж, төлөвлөгөөний дагуу урсгал засварын хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг сар бүр батлан хэрэгжилтийг хангаж ажиллаж байна. Уг төлөвлөгөөний хүрээнд суман шилжүүлэгт 1070 ш, гүүр хоолойд 662 ш, гарамд 48 ш үзлэг, хориг хашаанд нийт 32518 км-т үзлэгийг тус тус хийсэн.<br>Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.5 | Төмөр замын бүх өртөө, зөрлөгийн дохиолол холбооны байгууламж, Тетра тоон радио систем, галт тэрэгний хажуугийн илрүүлэх системүүд, тоног төхөөрөмжүүдэд техникийн засвар, үйлчилгээг хийх. | - | Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангасан эсэх | Батлагдсан жилийн ажлын зурмагийн дагуу шалгаж, технологи картын дагуу техникийн үйлчилгээг 100 хувь хийж ажиллах | **I улирал:** Нэгдсэн төлөвлөгөөг батлуулсан байна.<br>**I-IV улирал:** Дохиолол, төвлөрүүлэлт хориглолын ба холбооны байгууламж, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдлыг байнгын бүрэн хангаж, шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг зохион байгуулан ажилласан байна. | Суурь бүтцийн газрын Дохиолол холбоо, эрчим хүчний хэлтсийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр 5 зорилт, 45 арга хэмжээтэйгээр баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөний I улиралд хэрэгжүүлэхээр тусгагдсан арга хэмжээнүүдийн биелэлт 100 хувь байна.<br>Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн. | 100% |
| 3.6 | Эзэмшлийн шугам сүлжээ, дэд станцын тоноглолуудад шаардлагатай засвар үйлчилгээ хийх, нэгдсэн шугам сүлжээний энергийн алдагдлыг | - | Ажлын явц | Эрчим хүчний чанарын үндсэн үзүүлэлт, шугам сүлжээ, дэд станцын тоноглолын хэвийн ажиллагааг бүрэн хангаж ажиллах | **I улирал:** Нэгдсэн төлөвлөгөөг батлуулсан байна.<br>**I-IV улирал:** Эрчим хүчний шугам сүлжээ, дэд станцын аюулгүй байдлыг хангах, цахилгаан хэрэглэгчийн хэмнэлтийн тооцооллыг гаргах, гэмтэл тасралтаас байнгын урьдчилан сэргийлж ажилласан байна. | Суурь бүтцийн газрын Дохиолол холбоо, эрчим хүчний хэлтсийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр 5 зорилт, 45 арга хэмжээтэйгээр баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Үүнд:<br>-Power Factor программыг ашиглан эрчим хүчний горимын тооцоог;<br>-Гашуунсухайт өртөө 10/0.4кВ ХТП-4 дэд станцын трансформатороос | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тооцож төлөвлөгөөт урьдчилсан сэргийлэх үзлэгийн график батлуулж мөрдөж ажиллах. | | | | | тос гоожсоныг чангалгаа хийж том нэмсэн.<br>-Гашуунсухайт дэд станцын 35/10кВ Т-2 трансформаторт хий үүссэнийг хий авч үйлчилгээ;<br>-35/0.4кВ Шанх дэд станцын Т-1 трансформаторын буултын СИП кабель гэмтсэнийг, засварласан;<br>-Гашуунсухайт дэд станцын 35кВ-н Хүчдэлийн трансформатор-1 шинийн салгуурын С фазын хутганы тохиргоо алдсанг тохируулсан.<br>Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн. | |
| **Зорилт 4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллана.** | | | | | | | |
| 4.1 | Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох бусад хууль, | | Ажлын явц | ХАБЭА-н тухай Монгол улсын хууль, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын тушаал болон бусад тушаал шийдвэрийг мөрдөж ажилласан. | **I улирал:** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулсан байна.<br>**I-IV улирал:** Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн | Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хэлтсийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Хөдөлмөрийн аюулгүй байдал, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хանган ажиллах. | | | | тухай хууль, стандартын шаардлагад нийцсэн аюулгүй ажлын байр, ажиллах орчныг бүрдүүлж ажилласан байна. | эрүүл ахуйн тухай хууль, стандартын шаардлагад нийцсэн аюулгүй ажлын байр, ажиллах орчныг бүрдүүлэх ажлын хүрээнд Гамшгийн эрсдэлийн үнэлгээг "УСТ БЭЛЧИР" ХХК-тай гэрээ хийн Тавантолгой, гашуунсухайт өртөө болон нийт барилга байгууламжид аюулын 5 төрлөөр хийж гүйцэтгэсэн. Үнэлгээний явцад нийт ажилчдад Галын аюулгүй байдал, түүнд холбогдох хууль дүрмийн хүрээнд онолын сургалт, мөн гамшгийн эрсдэлийн сургалтыг тус тус зохион байгуулж 178 ажилтныг хамруулсан.<br>Шинэ ажилтны сургалт 7 хоногт 2 удаа зохион байгуулагдаж нийт 18 шинэ ажилтан сургалтад хамрагдсан.<br>Үйлдвэрлэлийн хортой, аюултай хүчин зүйлийн үйлчлэл бүхий болон тэдгээртэй адилтгах эрсдэлтэй ажлын байранд ажиллаж байгаа ажилтны сургалтыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.<br>Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үзлэг, хяналтыг 36 удаагийн хийж 134 үл тохирол илэрч, холбогдох арга хэмжээг авч ажилласан. Гүйцэтгэх захирлын баталсан тушаал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, холбогдох дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангахаар дотоод сургалтыг 34 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 1195 ажилтныг хамруулсан.<br>Аюулгүй ажиллагааны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зааварчилгааг 3 төрлөөр тайлант хугацаанд давхардсан тоогоор 3348 ажилтанд өгсөн байна.<br>5.6 дугаар саруудад Засгийн газрын 2025 оны 103 дугаар тогтоолын улмаас ажилтан, ажлын байр шилжсэн тул үйл ажиллагааг түр зогсоосон. | |
| 4.2 | Ажилтны эрүүл мэндийг дэмжих арга хэмжээг эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, эрүүл ахуйн стандарт, хэм хэмжээ, журмын хэрэгжилтийг хангах, Эрсдэлд суурилсан хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг хийлгэх. | | Ажлын гүйцэтгэл | "УБТЗ" ХНН-ийн харьяа нэгдсэн эмнэлэгт 2024 онд ХАГ2024/08 дугаартай гэрээний дагуу 300 ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулсан. | **I-II улирал:**<br>Эрсдэл өндөртэй 5 ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэж, ажиллах үеийн эрсдэлийн үнэлгээг хийсэн байна.<br>**I-IV улирал:**<br>Шинээр ажилд орж буй ажилтныг Эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдсан эсэхэд хяналт тавин ажилласан байна.<br>Нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамрагдсан эсэхэд хяналт тавин ажилласан байна.<br>**IV улирал:**<br>Галт тэрэгний хөдөлгөөний болон сэлгээний ажилд шууд холбоотой ажил үүрэг гүйцэтгэдэг 300 ажилтны эрүүл мэндийн хугацаат үзлэгт хамруулахад хяналт тавин ажилласан байна. | Хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээг "ДАБЛЬЮ ЭЙЧ ЭЙ" ХХК-тай АГГ/-2024/77 дугаартай гэрээ хийж, 31 ажлын байранд шөнийн болон өдрийн ээлжинд ажиллаж байгаа 206 ажилтныг хамруулан хувийн хэмжилтийн багаж зүүлгэн талбайн орчны хэмжилтийг хийсэн. Хэмжилтээр агаарын температур, чийгшил, шуугиан, угаарын хий, гагнуурын утаа, бүх биеийн доргио, гэрэлтүүлэг гар шууны доргион, агаарын урсгалын хурд, нүүрстөрөгчийн дутуу исэл хэмжин ажилласан.<br>Тайлант хугацаанд шинээр ажилд орсон 13 ажилтан урьдчилсан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамруулсан ба хугацаат эрүүл мэндийн үзлэгийг улсын төв 2 дугаар эмнэлэгтэй хамран зохион байгуулж 356 ажилтныг хамруулсан.<br>Ядаргаа, эргономик, химийн болон гэрэлтүүлгийн эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг тандах асуумжаар асууж эрсдэлийн үнэлгээг хийсэн.<br>Үнэлгээгээр: | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Давхардсан тоогоор Өндөр эрсдэл 20, дунд эрсдэл 15, бага эрсдэл 2 тодорхойлогдсон.<br>Эрсдэлийн үнэлгээний дагуу хяналтын арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Тайлант хугацаанд 11 аюулыг мэдээлэх хуудас ирж түүний мөрөөр залруулах арга хэмжээ авч ажлын байрны аюулгүй байдлыг ханган ажилласан. | |
| **Зорилт 5. Статистик судалгаа, мэдээ тайлангийн үнэн бодит, шуурхай, хүртээмжтэй байдлыг хангана.** | | | | | | | |
| 5.1 | Төмөр замын тээврийн үйл ажиллагаанд хөтлөгдсөн анхан шатны бичиг баримтуудыг бүртгэх, хянах, боловсруулах, тээврийн болон хөдлөх бүрэлдэхүүний тоон ба чанарын үзүүлэлтүүдийг тодорхойлох, галт тэрэгний хөдөлгөөний зурмаг шинжлэх, шуурхай мэдээ, хатуу тайланг гаргах, тайлагнах. | | Ажлын гүйцэтгэлийн хувь,<br>Тайлангийн тоо | 2024.11.17-ны өдрийн байдлаар:<br>Хоногийн мэдээ 323;<br>Сарын тайлан 11;<br>Улирлын тайлан 3;<br>Хагас жилийн тайлан 2;<br>Жилийн эцсийн тайлан 1-ийг тус тус хугацаанд нь гаргаж, тайлагнан ажилласан. | **I-IV улирал:** Хоногийн мэдээг 17:00 цагаар тасалбар болгож, тухайн өдрийн 20:00 цагийн дотор гаргаж хүргүүлсэн байна.<br>Сар, улирал, хагас жил болон жилийн эцсийн байдлаар мэдээ, тайланг дараа сарын 10-ны өдрийн дотор гаргаж, компанийн хэмжээнд болон төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудад тайлагнасан байна.<br>Мэдээ тайланг 100% үнэн бодит гаргасан байна. | Тээврийн үйл ажиллагааны хоногийн мэдээг 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн байдлаар өдөр бүр 17:00 цагт гаргаж, нийт 85 өдөр танилцаж ажилласан.<br>Тээврийн анхан шатны бичиг баримтын тулгалт шалгалтыг нэг бүрчлэн хийж, илэрсэн алдаа, дутагдлыг арилгуулан, төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тайланг хүргүүлсэн.<br>-Сарын тайлан 3/3;<br>- Улирлын тайлан 1/1;<br>- Жилийн эцсийн тайлан 1-ийг тус тус хугацаанд нь гаргаж ажилласан.<br>Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн.<br>2025 оны 1-р улирлаас хойш хийсэн ажил юу байна? | |
| 5.2 | Ачаа тээвэр, хөдөлгөөн зохион байгуулалт, зүтгүүрийн ашиглалтын чиглэлээрх үйл ажиллагаанд программ хангамжийг бүрэн нэвтрүүлэх. | | Ажлын гүйцэтгэл, хувь | Ачаа тээвэр, хөдөлгөөн зохион байгуулалтын чиглэлээр программ хангамжийг үйл ажиллагаандаа туршилтаар ашиглаж байна. | **I-II улирал:** Төмөр замын ачаа тээвэр, галт тэрэгний хөдөлгөөн зохион байгуулалтын болон зүтгүүрийн программ хангамжийн үйл ажиллагааг зүгшрүүлсэн байна.<br>**III улирал:** Төмөр замын ачаа тээвэр, захиалга, хөдөлгөөн зохион байгуулалт, зүтгүүрийн ашиглалт болон тайлан мэдээний программ хангамжийг үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлсэн байна.<br>**IV улирал:** Төмөр замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон харилцагч байгууллагуудтай программ хангамжийн хүрээнд мэдээллийг харилцан солилцож эхэлсэн байна. | Ачаа тээвэр, хөдөлгөөн зохион байгуулалт, зүтгүүрийн ашиглалтын чиглэлээр программ хангамжийг үйл ажиллагаандаа туршилтаар ашиглаж байна. Гэрээний дагуу 6 багц программ, 2 тоног төхөөрөмж нийлүүлэхээс ачаа тээвэр, хөдөлгөөн зохион байгуулалтын программ, зүтгүүр, шуурхай мэдээний аппликейшн, тайлангийн программуудыг үйл ажиллагаандаа тус тус нэвтрүүлсэн.<br>Гэрээний дагуу Сервер болон Файрбол тоног төхөөрөмжийг 2025 оны 01 дүгээр сард Тавантолгой өртөөнд суурилуулсан бөгөөд программын хурд, найдвартай ажиллагаа, хамгаалалтыг бүрэн шийдвэрлэсэн.<br>Гэрээний хугацаа 2025 оны 06 дугаар сард дуусах бөгөөд программ хангамж нэвтрүүлэх явцад гарсан асуудлыг тухай бүр шийдэж, шаардлагатай хөгжүүлэлтийг хийн, ажиллагсдад сургалт өгч ажиллаж байна.<br>Засгийн газрын 2025 оны "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглалттай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, Зам тээврийн сайд, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын хамтарсан 2025 оны А/75, А/18 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг "Монголын төмөр зам" ТӨХК-д түрээсийн гэрээгээр ашиглуулах, "Тавантолгой төмөр зам" ХХК-иас шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлсэн. | |
| **Зорилт 6. Байгаль орчны багц хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангана.** | | | | | | | |
| 6.1 | Төмөр замуудын БОННҮ-нд тодотгол хийлгэж, батлуулах. | 200,0 | БОННҮ тодотгол хийлгэж батлуулах эсэх | Эхний хувилбар хийгдсэн. | **I улирал:** Мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулсан байна.<br>**II-III улирал:** БОННҮ-ний боловсруулалтын ажлыг гүйцэтгүүлсэн байна.<br>**IV улирал:** БОУАӨЯ-нд хүргүүлж, батлуулсан байна. | Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/504 тоот "Чиглэл хүргүүлэх тухай", "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд худалдан авалтын үйл ажиллагааг зогсоосон. | 0 |
| 6.2 | "Тэрбум мод үндэсний хөдөлгөөн"-ий хүрээнд модны тарьц суулгац тарих. | Батлагдсан төсвийн дагуу 50,0 | Тарьсан модны тоо | "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 онд 10000 ширхгээс доошгүй мод тарьсан байна. | **I улирал:** ААН-ийг сонгож гэрээ байгуулсан байна.<br>**II улирал:** 5000ш-ээс доошгүй модны суулгац тариалсан байна.<br>**III улирал:** 5000ш-ээс доошгүй модны суулгац тариалсан байна.<br>2025 онд нийт 10000 ш-ээс доошгүй мод суулгацыг ТТГС чиглэлийн төмөр замын дагууд тариалсан байна. | Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/504 тоот "Чиглэл хүргүүлэх тухай", "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд худалдан авалтын үйл ажиллагааг зогсоосон. | 0 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 6.3 | Хөв байгуулах, зураг төсөв батлуулах. | Төсөв батлагдсан тохиолдолд<br><br>400,0 | Барилгын ажлыг эхлүүлсэн эсэх | 2025 оны төсвийн төсөлд тусгасан. | **I-II улирал:** Хөвийн зураг төсвийг батлуулсан байна.<br>**IV улирал:** Үерийн усыг хуримтлуулах зорилгоор хөв байгуулах төслийг батлуулж, барилгын ажил эхлүүлсэн байна. | Зам, тээврийн сайдын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 01/504 тоот "Чиглэл хүргүүлэх тухай", "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн хүрээнд худалдан авалтын үйл ажиллагааг зогсоосон. | 0 |
| **Зорилт 7. Санхүү, эдийн засаг, хөрөнгө оруулалтыг төлөвлөн зохицуулна.** | | | | | | | |
| 7.1 | Компанийн хөрөнгө оруулалт, эдийн засгийг үр ашигтай оновчтой төлөвлөх. | | Тайлан гаргаж, удирдлагад танилцуулсан эсэх | 2025 онд мөрдөж ажиллах эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөний дагуу | **I-IV улирал:** Батлагдсан төлөвлөгөөний дагуу Компанийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр, тээврийн үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэлийг хянаж, үйл ажиллагааны чиглэл тус бүрээр гүйцэтгэлийн тайланг гарган, тайлбарын хамт удирдлагад танилцуулсан байна. | Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 13 дугаар тогтоолоор Компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин ба хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг хангаан ажиллаж байна.<br>Компанийн мөнгөн хөрөнгийн чөлөөт үлдэгдэлд менежмент хийж, үйл ажиллагаанд шууд зарцуулагдахгүй хэсгийг хугацаатай хадгаламж үүсгэх замаар хүүгийн орлогыг төвлөрүүлэн ажилласан. Үүний үр дүнд мөнгөн хөрөнгө эргэлтэд орж, нийт 8,414.3 сая төгрөгийн хүүгийн орлого олсон.<br>2025 оны 1 дүгээр улирлын санхүү, эдийн засгийн гүйцэтгэлийн тайланг гарган, тайлбарын хамт удирдлагад танилцуулсан. 2025 оны эхний хагас жилийн санхүү, эдийн засгийн гүйцэтгэлийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу компанийн санхүүгийн эхний хагас жилийн тайлан гарсны дараа гүйцэтгэлийн тайланг гарган, | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тайлбарын хамт удирдлагад танилцуулна. | |
| 7.2 | Төрийн хэмнэлтийн хууль болон Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023 оны А/333 дугаартай албан бичгээр өгөгдсөн үүргийг тус тус хэрэгжүүлэх хүрээнд "Орлого нэмэгдүүлж, зардал бууруулах төлөвлөгөөг"-г боловсруулан, батлуулж биелэлтийг хангаж ажиллах. | | Төлөвлөгөө батлуулж, тайлагнасан эсэх | 2024 оны III улирлын ХБГ-ээр орлого нэмэгдүүлэх төлөвлөгөөний биелэлт 37-иар давуулан биелүүлсэн ба зардал бууруулах төлөвлөгөө 4 дахин давж тус тус үр дүнтэй биелсэн. | **I улирал:** Орлого нэмэгдүүлэх, зардал бууруулах төлөвлөгөөг боловсруулан Гүйцэтгэх удирдлагаар батлуулсан байна.<br>**II-IV улирал:** Төлөвлөгөөний биелэлтийн тайланг гаргаж, гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр улирал бүр хангасан байна. | Орлого нэмэгдүүлж, зардал бууруулах ажлын төлөвлөгөөг 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн Гүйцэтгэх захирлын А/12 тоот тушаалаар баталж, хэрэгжилтийг хангаж ажиллаж байна.<br>Монгол Улсын Засгийн газрын 103 дугаар тогтоолын хэрэгжилтийн хүрээнд бүтэц орон тоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор уг чиг үүргийн хүрээнд ажиллаж байсан зарим нэгж, албан тушаалын хэрэгцээ шаардлага хүчингүй болж, орон тооны хэмнэлт хийгдсэн. 2025 оны 2-р улирлын хүлээгдэж буй гүйцэтгэлээр зардал бууруулах ажлын төлөвлөгөөг 16,058.59 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан.<br>Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан гарсны дараа буюу санхүүгийн тайлангаар баталгаажсан дүнгээр "Орлого нэмэгдүүлж, зардал бууруулах төлөвлөгөөг" -ний гүйцэтгэлийн тайланг гарган, тайлбарын хамт удирдлагад танилцуулна. | 70% |
| 7.3 | Гашуунсухайт-Ганцмод боомт чиглэлийн хил холболтын төмөр замын төслийн санхүүжилтийн мэдээг гаргах. | | Ажлын явц | УИХ-ын 2023 оны 68 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны 310 дугаар тогтоол тус тус батлагдсан. | **III-IV улирал:** Санхүүжилтийн гэрээ ба Барилга угсралтын ажлын гэрээнд заасан захиалагчийн хяналтын санхүүжилттэй холбоотой тайланг төслийн явцтай нийцүүлэн боловсруулж, удирдлагыг мэдээллээр хангасан байна. | Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын төслийн барилгын ажил гүйцэтгэх гэрээний хэлэлцээрийг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Гүйцэтгэгч талтай хийгээд байна. Тус төслийн Санхүүжилтийн гэрээ болон гэрээний тусгай нөхцөл, гэрээний нэмэлт өөрчлөлт хийгдсэний дараа 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний | ХБ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төлөвлөгөөнд тодотгол хийх нөхцөл бүрдэнэ. Төслийн тендерт шалгарсан төсөвт өртөг 848.9 тэрбум төгрөг бөгөөд санхүүжилтийн гэрээ, барилга угсралтын ажлын гэрээ байгуулагдсан. Төсвийг 54.7 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 903.6 тэрбум болгон гэрээг байгуулсан. | |
| 7.4 | Компанийн хэрэгжүүлж байгаа төслүүдийн гүйцэтгэлийн мэдээг гаргах. | - | Ажлын явц | 2024 оны байдлаар: - "ТНАЛТ" төслийн гүйцэтгэлийг баталгаажуулж, захиалагчийн хяналтын орлогын гүйцэтгэл 97 хувьтай. - "Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Зүүнбаян"-ын төмөр замуудыг холбох төмөр замын төслийн гүйцэтгэлийг баталгаажуулж, захиалагчийн хяналтын санхүүжилтийн гүйцэтгэл 78 хувьтай. - "Тавантолгой-Гашуунсухайт" чиглэлийн төмөр замын төслийн гүйцэтгэлийг баталгаажуулж, захиалагчийн хяналтын санхүүжилтийн гүйцэтгэл 82 хувьтай байна. | **I-IV улирал:** Төсөл дууссантай холбоотойгоор захиалагчийн хяналтын санхүүжилтийн тайланг гарган, гэрээний дүнг шалгаж, үр дүнгийн талаарх мэдээллийг удирдлагад танилцуулсан байна. | "ТНАЛТ" төслийн санхүүжилт 313,192 сая төгрөг байхаас 99 хувь буюу 309,639 сая төгрөгний гүйцэтгэлтэй байна. IPC 11 хянагдах шатандаа явж байна. "Тавантолгой-Гашуунсухайт", "Тавантолгой-Зүүнбаян"-ийн Холболтын төмөр замын суурь бүтцийг ашиглалтад оруулах комиссын дүгнэлт 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр гарч, дүгнэлтийг үндэслэн Холболтын төмөр зам төслийн IPC-009, 010-ийг баталгаажуулж, "Бодь интернэшнл" хүргүүлсэн. Нийт төслийн гүйцэтгэл 96 хувьтай байна. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын бүтээн байгуулалтын төслийн IPC 24, 25, 26, 27 захиалагчийн зүгээс баталгаажуулж, "Бодь интернэшнл" ХХК-д хүргүүлсэн. IPC-28 хүлээгдэж буй гүйцэтгэлээр ерөнхий гүйцэтгэгч, захиалагчид ногдох санхүүжилтийн дүнг тооцон тайланг боловсруулсан. Захиалагчийн хяналтын санхүүжилт 83 хувийн гүйцэтгэлтэй байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 7.5 | Компанийн 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулан, Төлөөлөн удирдах зөвлөлөөр батлуулах. | - | Батлуулсан эсэх | Компанийн 2025 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг батлуулсан. | **IV улирал:** Компанийн 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулан, компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулсан байна. | Хугацаа болоогүй. | - |
| 7.6 | Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудитын байгууллагын шалгалтын зөвлөмжийг хэрэгжүүлэх. | - | Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь | Аудитын 2 удаагийн зөвлөмжийн хэрэгжилтийг Үндэсний аудитын газарт хүргүүлсэн. | **II улирал:** Аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу хэрэгжүүлэх ажлын төлөвлөөг батлуулсан байна.<br>**II-III улирал:** Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж, өгсөн зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна. | 2024 оны санхүүгийн аудитын тайлангаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг ТУЗ-ийн ажлын албанд хүргүүлж танилцуулан хэлэлцүүлж батлуулсан. Санхүүгийн аудитын төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 15-нд гүйцэтгэх захирлаар батлуулан ПАСС/www.pass.audit.mn/ аудитын программд шивж оруулсан. Төлөвлөгөөнд тусгагдсан асуудлыг заасан хугацаанд нь хэрэгжүүлэхээр ажиллаж байна. | 100% |
| 7.7 | Компанийн батлагдсан төсвийн дагуу гүйцэтгэлээр зардлын санхүүжилтийг олгож хяналт тавьж, нэгтгэсэн санхүүгийн | | Тайланг хугацаанд нь хүргүүлсэн эсэх | 2024 оны хагас жилийн тайланг 7 дугаар сарын 20-ны дотор гаргаж, тайлагнасан. | **I улирал:** 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор.<br>**III улирал:** Хагас жилийн санхүүгийн тайланг 2025 оны 07 дугаар сарын 20-ны дотор тус тус гаргаж холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. | 2024 оны санхүүгийн жилд 127,5 тэрбум төгрөгийн орлоготой, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 67,1 тэрбум, ерөнхий удирдлагын зардал 10,3 тэрбум төгрөг, үйл ажиллагааны бус зардал 15,3 төгрөгийн тус тус зардалтай 39,9 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, холбогдох тайланг www.etailan.mn, www.ebalance.mn, www.etax.mn | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тайлан гаргаж, тайлагнах. | | | | | цахим системд хугацаанд нь тайлагнаж ажилласан. | |
| **Зорилт 8. Эрх бүхий дээд байгууллагын шийдвэрийг хангаж, захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг ханган ажиллана.** | | | | | | | |
| 8.1 | Хууль тогтоомж, Засгийн газар, төрийн бусад эрх бүхий дээд байгууллагын шийдвэр, удирдамж, чиглэлд нийцүүлэн ажиллаж, хэрэгжилтийг хангуулах. | - | Хэрэгжилтийн хувь | Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ЗТЯ-нд 10 удаа хүргүүлсэн. | **I-IV улирал:** Хууль тогтоомжийн хэрэгжилтийг 100 хувь хангуулж, дээд шатны байгууллагад хэрэгжилтийг хүргүүлэн ажилласан байна. | Компанийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа төсөлтэй холбогдуулан Төмөр замын тээврийн тухай хууль, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээг Компанийн Гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй нягт уялдуулан зохион байгуулж, улирал тутам хэрэгжилтийг ЗТЯ-ны ХШҮДАГ-т хүргүүлэн ажиллаж байна. Дээд газрын тогтоол, шийдвэрээр өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг сар бүр заасан хугацаанд нь ЗТЯ-нд хүргүүлсэн. | 70% |
| 8.2 | Хувьцаа эзэмшигчдийн хурал болон Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр, тогтоол, Гүйцэтгэх захирлын тушаалыг хэрэгжүүлж, тайлагнах, мэдээллээр хангах. | - | Ажлын гүйцэтгэлээр | Шийдвэрт нийцсэн эдийн засгийн тооцоо, санхүүгийн бүртгэл хийсэн. | **I-IV улирал:** Хувьцаа эзэмшигчид болон төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын хэрэгжилтийг тухай бүр хангуулан ажилласан байна.<br>**I-IV улирал:** Гүйцэтгэх захирлын тушаалыг хэрэгжүүлж, тухай бүр тайлагнан ажилласан байна. | Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл 2025 оны эхний хагас жилийн байдлаар Хувьцаа эзэмшигчдийн хурал 2 удаа хуралдаж, 5 асуудал хэлэлцэж, 5 тогтоол 2 хурлын тэмдэглэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 7 удаа хуралдаж, 13 асуудал хэлэлцэж, 8 тогтоол 4 тэмдэглэл гаргасан, ТУЗ-ийн Нэр дэвшүүлэх хороо 2 удаа хуралдаж 2 дүгнэлт, Аудитын хороо 4 удаа хуралдаж 5 асуудал хэлэлцэж, 4 дүгнэлт тус тус гаргасан бөгөөд хэрэгжилтийг хангаан ажилласан. Компанийн үйл ажиллагааг хэвийн тогтвортой явуулах, ажлын хариуцлага, сахилга батыг сайжруулах ажлын хүрээнд 57 тушаал, хүний нөөцтэй холбоотой | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 829 тушаал баталж, хэрэгжилтийг хангаж ажилласан. | |
| 8.3 | Хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангах. | - | Хэрэгжилтийн хувь | 2024 онд Бодлогын бичиг баримт бичгүүдийг бүх ажилтнуудад таниулан ажилласан. | **I-IV улирал:** Төмөр замын тээвэрлэлтийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардлагатай хүний нөөцөөр хангах | "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн "Ажилтан шинээр авахгүй байх, туршилтын гэрээгээр ажиллаж буй ажилтнуудыг үндсэн ажилтан болгон хөдөлмөрийн гэрээ байгуулахгүй байх" чиглэлийг баримтлан ажиллаж байна.<br>Тайлант хугацаанд орон тоог гүйцэтгэлээр нь авч үзвэл:<br>01 сард орон тоо гүйцэтгэл 781;<br>02 сард орон тоо гүйцэтгэл 769;<br>03 сард орон тоо гүйцэтгэл 765;<br>04 сард орон тоо гүйцэтгэл 752;<br>05 сард орон тоо гүйцэтгэл 334;<br>06 сард орон тоо гүйцэтгэл 202.<br>Засгийн газрын 2025 оны 103 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор "Монголын төмөр зам" ТӨХК-д шаардлагатай чиг үүрэг, орон тоог шилжүүлэх арга хэмжээний хүрээнд тээвэр, суурь бүтэц, дэмжих чиг үүргийн 700 ажилтнуудын тоон мэдээллийг хүргүүлж, "Монголын төмөр зам" ТӨХК-иас 341 ажилтныг үндсэн, 139 гэрээгээр нийт 480 ажилтныг ажлын байраар хангах боломжтой талаар албан бичгээр мэдэгдсэн. Энэхүү ажил үүргийн хүрээнд "Монголын төмөр зам" ТӨХК--ний 482 ажилтныг шилжүүлсэн ажилласан. | 90% |
| 8.4 | Компанийн гадаад, дотоод сургалтын төлөвлөгөөг | - | Тоо хэмжээ | 2024 оны сургалтын төлөвлөгөөний дагуу 28 төрлийн дотоод сургалтад 461, 3 | **I-IV улирал:** Батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу гадаад, дотоодын | Гүйцэтгэх захирлын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/10 дугаар тушаалаар батлагдсан сургалтын төлөвлөгөөний хүрээнд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлан хэрэгжүүлэх. | | | төрлийн гадаад сургалтад 16 ажилтныг тус тус хамруулсан. | сургалтад тогтмол хамруулсан байна. | Суурь бүтцийн газрын Дохиолол холбоо, эрчим хүчний хэлтсийн 2 ажилтныг ШУТИС-ийн Эрчим хүчний инженерчлэлийн сургуулиас зохион байгуулсан "Эрчим хүч хэмнэлтийн менежер бэлтгэх" сургалтад хамруулсан. Төлөвлөгөөт бус сургалтаар нийт 82 ажилтныг Эйбл Софт программын сургалтад хамруулсан. Шинэ ажилтны чиглүүлэх сургалтад 12 ажилтныг хамруулан тус тус ажилласан.<br>"Тавантолгой төмөр зам" ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн А/07 дугаар албан бичгээр ирүүлсэн чиглэлийн дагуу төсөвт сургалтын үйл ажиллагааг зогсоосон болно. 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр төсвийн тодотголд байгууллагын шинэчилсэн бүтцийн хүрээнд зохион байгуулагдах сургалтыг тусган хүргүүлэн ажилласан болно. | |
| 8.5 | Авлигын эсрэг төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийг хангаж ажиллах. | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | 41 албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг хянуулж, хувийн ашиг сонирхол, хөрөнгө оруулгын мэдээллийг гаргуулан баталгаажуулсан. | **I улирал:** Компанийн 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулах.<br>**II улирал:** Удирдах болон эрх бүхий албан тушаалтны хувийн ашиг сонирхол, хөрөнгө оруулгын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд шинэчлэн Авлигатай тэмцэх газарт хүргүүлж, хуулийн хугацаанд хянуулсан байна.<br>**III улирал:** Авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, авлигыг үл тэвчих үзлийг төлөвшүүлэх зорилгоор | 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр компанийн 2025 оны авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг Гүйцэтгэх захирлаар батлуулсан.<br>Нийтийн албан тушаалд томилогдохоор нэр дэвшсэн 14 этгээдийн ХАСУМ-ийг хянуулж, 27 албан тушаалтны ХАСХОМ-ийг шинэчлэн гаргуулж, шинээр томилогдсон 8 албан тушаалтны ХАСХОМ-ийг гаргуулан баталгаажуулсан.<br>Авлигатай тэмцэх газарт хандаж, компанийн эрх бүхий албан тушаалтнуудад авлигын эсрэг сэдвээр сургалт авахаар хүсэлт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | компанийн эрх бүхий ажилтнуудад зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг АТГ-тай хамтран зохион байгуулах.<br>**IV улирал:** АТГ-ын зохион байгуулах Авлигын эсрэг үе шаттай сургалтад эрх бүхий албан тушаалтнуудыг хамруулсан байна. | хүргүүлсний дагуу 2025 оны 3 дугаар улиралд АТГ-аас сургалт зохион байгуулахаар болсон. | |
| 8.6 | Мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах. | - | Хэрэгжилтийн хувь | 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 55 мэдээ, 30 видео контент, 14 инфографик, 30 постер нийт 129 мэдээ, мэдээлэл бэлтгэн давтагдсан тоогоор 24 телевиз, 42 сайт, өдөр тутмын сонин, www.ttz.mn веб сайт, байгууллагын фэйсбүүк пэйж хуудсанд байршуулсан.<br>Олон нийтэд компанийн үйл ажиллагааг сурталчилж, 540 мэдээ мэдээллийг оруулан ажилласан.<br>Хуулийн хүрээнд нийт 117 мэдэгдлийг хүргүүлсэн. | **I-IV улирал:** Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тухай бүр хангаж ажиллана. | "Мэдээллийн ил тод байдлын тухай" хууль болон "Шилэн дансны тухай" хуулийн хэрэгжилтийг хангаж, тухай бүр шаардлагатай мэдээллийг байршуулан ажилласан.<br>"Шилэн дансны цахим хуудас хөтлөх журам"-ын хавсралтын дагуу 43 мэдээ, мэдээллийг байршуулсан.<br>"Нийтийн ил тод байдлын тухай хууль"-ийн хэрэгжилтэд байгууллагын Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын албанаас хяналт шалгалт хийж, шинэчлэл хийх зөвлөмж ирүүлсний дагуу байгууллагын веб сайтад "НЭЭЛТТЭЙ МЭДЭЭЛЭЛ" цэсийг шинээр үүсгэж мэдээллийг шинэчлэн байршуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>2025 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн байдлаар мэдээ 45, видео контент 8, постер 11, инфографик зэрэг нийт 60 гаруй контентыг бэлтгэж www.ttz.mn веб сайт болон байгууллагын фэйсбүүк пэйж хуудсанд байршуулсан.<br>Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын шав тавих ёслол 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | болох үеэр хэвлэл мэдээллийн 33 байгууллагын / телевиз, сайт, сонины/ сурвалжлах үйл ажиллагааг зохион байгуулж тайлан авсан бөгөөд 10 гаруй телевиз, сайт лайваар шууд дамжуулж 100 гаруй мэдээ, мэдээлэл нийтлэгдсэн. Гашуунсухайт–Ганцмод чиглэлийн төмөр замын анхны тулгуур шонгийн цэгт ёслолын ажиллагаа 2025 оны 06 дугаар сарын 15-нд эхлүүлэх үеэр МҮОНТ-ийн багийг ажиллуулж, 10 гаруй хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулж мэдээлэл бэлтгэж олон нийтэд хүргэсэн. | |
| 8.7 | Батлагдсан төсвийн хүрээнд компанийн худалдан авах ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, тайлагнах. | - | Хэрэгжилтийн хувь | 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан 200 төсөл арга хэмжээг 19 тэрбум төгрөгөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. | **I улирал:** Компанийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулах.<br><br>**II-IV улирал:** Компанийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. | Компанийн 2025 оны батлагдсан төсвийн хүрээнд Гүйцэтгэх захирлын 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар "Тавантолгой төмөр зам" ХХК-ийн 2025 оны Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтаар 52 төсөл арга хэмжээг 36.5 тэрбум төгрөг, урсгал зардлаар 257 төсөл арга хэмжээг 51.8 тэрбум төгрөгөөр хэрэгжүүлэхээр тус тус төлөвлөсөн. Зам тээврийн сайд болон Тавантолгой төмөр зам ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн чиглэл хүргүүлэх тухай албан бичгийн хүрээнд ТТЗ ХХК-ийн суурь бүтэц, хөдлөх бүрэлдэхүүнийг МТЗ ТӨХК руу шилжүүлж байгаатай холбогдуулан үндсэн үйл ажиллагаатай холбоотой бараа материал, сэлбэг худалдан авах ажиллагааг зогсоосон. 2025 оны 06-р сарын 23-ны өдрийн байдлаар 17 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төсөл арга хэмжээг 190 сая төгрөгөөр хэрэгжүүлээд байна. Гашуунсухайт боомт хүртлэх 3.9 км-ын авто зам, Юнион оффисын В блокын агааржуулалтын системийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог байгуулагдсан. | |
| 8.8 | Компанийн суурь бүтцээр тээвэрлэгдэж байгаа аюултай ачааны хамгаалалт, төмөр замын обьект, тусгай бүс, Гаалийн хяналтын талбайн аюулгүй байдлыг хангаж ажиллах. | - | Тоо хэмжээ | 2024 онд хамгаалалтын 11 цэгт 72008 хүн/цаг ажиллан өртөө болон Шилжүүлэн ачих терминал, Гаалийн хяналтын талбайд 48044 автомашин, 35733 хүнийг шалган нэвтрүүлж, Гаалийн хяналтын талбайд 30156 автомашиныг байрлуулан хөдөлгөөн зохицуулалт хийсэн. Гаалийн байцаагчийн зөвшөөрлөөр гаалын хяналтын талбайгаас нүүрс тээврийн 24940 автомашин гарах үед 99760 чингэлэгийн дугаар тулгалт хийж нэвтрүүлсэн. Өртөөний зам паркад 1729 вагон цистерн, 37 битүү вагонтой тэсэлгээний бодис /амоны нитрат/ ирэх үед ачаа вагон хүлээлцэгч нараас хүлээн авч аюултай ачаа вагонд | **I улирал:** Хариуцсан нэгжийн 2025 оны хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.<br><br>**I-IV улирал:** Төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээний дагуу үйл ажиллагааг зохион байгуулсан байна. | Харуул хамгаалалтын хэлтсийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сард Захиргаа удирдлагын газрын даргаар батлуулж, хэрэгжилтийг хангаж ажилласан. Төмөр замын талбайд хамгаалалтын 10 цэгт 41 ажилтан 27534 хүн цаг ажилласан. Гашуунсухайт Шилжүүлэн ачих терминал, Гаалийн хяналтын талбайд 50921 автомашин, 39586 хүн шалган нэвтрүүлж, 32890 автомашины хөдөлгөөн зохицуулалт хийж Гаалийн байцаагчийн зөвшөөрлөөр 25203 автомашин гарах үед 100812 чингэлгийн дугаар тулгалт хийж нэвтрүүлсэн. Паркийн замд АВХ нараас 2047 вагон цистерн, 46 битүү вагон амоннийн нитрат /тэсэлгээний бодис/ хамгаалалтад хүлээн авч, паркийн замд зөрчилгүй хамгаалж, ачаа вагон хүлээлцэгч нарт буцаан хүлээлгэн өгч ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хамгаалалт хийж ажилласан. | | | |
| 8.9 | Компанийн ажилтнуудыг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн чанартай хоол хүнсээр үйлчлэх, амрах байраар хангах. | - | Тоо хэмжээ | 2024 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар давхардсан тоогоор 79,750 инженер техникийн ажилтан Тавантолгой өртөөнд 115,717, Гашуунсухайт өртөөнд 45,849 хоолны захиалга тус тус хийгдэж хоол хүнсээр үйлчилсэн байна. | **I улирал:** Ажилтнуудад эрүүл ахуйн шаардлагад нийцсэн чанартай хоол ундаар үйлчилж, тав тухтай ажиллаж, амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.<br>**I-IV улирал:** Төмөр замын аюултай бүсийн дэглэм, хөдөлмөрийн дотоод журмыг хангуулах, сахилга дэг журам сахиулах, төмөр замын объект, тээвэрлэж байгаа ачаа, тээшний аюулгүй байдлыг хангах хамгаалалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангана. | Тайлант хугацаанд давхардсан тоогоор 24,500 инженер техникийн ажилчдад Тавантолгой өртөөнд 52800, Гашуунсухайт өртөөнд 18815 өглөө, өдөр, орой, шөнө хоолны захилга тус тус хийгдэж, тав тухтай ажиллаж, амьдрах орчин нөхцөлөөр хангаж ажилласан.<br>Төмөр замын аюултай бүсийн дэглэм, хөдөлмөрийн дотоод журмыг хангуулах, сахилга дэг журам сахиулах, төмөр замын объект, тээвэрлэж байгаа ачаа, тээшний аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд 15 зөрчлийг шалгаж тогтоон, зөрчил гаргасан 19 ажилтанд зөрчлийн хуудас бичиж бүртгэн, зөрчлийн материалыг хариуцсан нэгжид хүргүүлэн ажилласан. | 100% |
| 8.10 | Компанийн гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлэх. | - | Ажлын явц | - Гадаад хамтын ажиллагааны хүрээнд:<br>Санамж бичиг-1<br>Албан уулзалт-10<br>Албан томилолт-4<br>Гадаад хэл дээрх аман орчуулга-10<br>Гадаад хэл дээрх бичгэн орчуулга-80 хуудас<br>- Дотоод хамтын ажиллагааны хүрээнд:<br>Нийгмийн хариуцлагын хүрээнд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын ЕБС-ийн II сургуулийн багш, ажилчидад | **I улирал:** 2025 онд хийгдэх гадаад, дотоод хамтын ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулна<br>**II улирал:** Олон улсын төмөр замын хамтын ажиллагааны байгууллагад гишүүнчлэлээр элсэх ажлыг зохион байгуулж, элссэн байна<br>**III-IV улирал:** Компанийн гадаад хамтын ажиллагааны хүрээнд техник технологи, сургалт, туршлага судлах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна.<br>- Дотоод хамтын ажиллагааны хүрээнд | Гадаад үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөөг 4 чиглэлийн хүрээнд 20 ажил, арга хэмжээтэйгээр төслийг боловсруулж, Захирлын зөвлөлийн хуралд хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг хангаж байна. | 30% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | компанийн хэрэгжүүлж байгаа бүтээн байгуулалтын ажлыг танилцуулсан. | орон нутгийн байгууллага, удирдлагуудтай хамтран ажиллаж хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна.<br>- Ажилчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, хамт олны дотоод уур амьсгал, эв нэгдэл, хандлагыг эерэг болгож байгууллагын соёлыг түгээн дэлгэрүүлэх ажлууд хийгдсэн байна. | | |
| 8.11 | Суурь бүтэц эзэмшигч байгууллагуудын хооронд ачааны хэмжээ тохирох хурлыг оролцох. | - | Хурал зохион байгуулсан эсэх | Хуралд оролцох бэлтгэл ажлыг хангаж ажиллана. | **III-IV улирал:** Бүх төмөр замын байгууллагуудын тухайн жилд ямар төрлийн хэдэн тонн хэмжээний ачаа, барааг суурь бүтэц эзэмшигч хоорондоо тээвэрлэх талаар тохирох хурлыг зохион байгуулсан байна. | Хугацаа болоогүй | ХБ |
| **Зорилт 9. Компанийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн хяналт, үнэлгээ хийнэ.** | | | | | | | |
| 9.1 | Компанийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн хяналт шинжилгээ, үнэлгээ хийх. | - | Хэрэгжилтийн хувь | Компанийн үндсэн үйл ажиллагаа, бодлого, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, төсөв, санхүүгийн байдалд хяналт шалгалт, дотоод аудит хийж үр дүн үр дагаврыг үнэлэн, үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө, дэмжлэгээр цаг тухай бүр хангаж ажилласан. | **I-IV улирал:** Хууль, тогтоомжийн шийдвэрийг хангаж ажиллаж, 2025 оны хийгдэх ажлыг 95 хувиас дээш дүгнүүлсэн байна. | Компанийн үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн байдалд хяналт шалгалт, дотоод аудит хийж үр дүнг тухай бүр удирдлагад танилцуулж байна. | 30% |
| 9.2 | Компанийн хэмжээнд мөрдөгдөж | - | Хэрэгжилтийн хувь | Бодлогын баримт бичгүүдийн 2024 оны хэрэгжилт III улирлын | **I-IV улирал:** Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан журамд нийцүүлэн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон Компанийн 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийж, ЗТЯ-нд хүргүүлэх. | | | байдлаар 88.13 хувьтай байна. | батлагдсан журамд нийцүүлэн үнэлгээ хийж, үнэлгээг тухай бүр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн байна. | үнэлгээ хийж, үнэлгээг тухай бүр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. | |
| Дундаж хувь | | | | | | | 73.8 |

***Төлөвлөгөөг хянасан:***
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД

***Төсвийн ерөнхийлөн захирагч***

............................ /Б.ДЭЛГЭРСАЙХАН/
20 25 оны 09 сарын 24 өдөр

***Төлөвлөгөө тайлагнасан:***
"ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ"
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

***Төсвийн шууд захирагч***

............................ / Б.ДҮГЭРЖАВ /
20.... оны ....... сарын .......... өдөр